



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМД**

2020.08.10 № 215  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Шивээговь сумын Монгол ардын нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Шивээговь сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шивээговь сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр 1.6 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд  
Хавсралт 6.. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\2020\Alban toot.doc

0080200363

**ШИВЭЭГОВЬ СУМЫН МАН-ААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ГЭР БҮЛИЙН  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:**

1.1.Зорилтот бүлгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулан тэдний амьдралын онцлог хэрэгцээ, чадамжид тулгуурлан хэрэгжүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэх

1.2.Хүүхэд залуучуудад ажлын байр бий болгоход чиглэсэн мэргэжлийн сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих.

1.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан залуучууд хүүхэд гэр бүлийн нийгмийн хамгаалалын асуудлаар дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

1.4.Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжиж ажиллах. /2,3,6,7,8,9,10,12,13,14,15 байруудад хүүхдийн тоглоомын талбайг сайжруулах болон шинээр байгуулах/

1.5. “Залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх

**ХОЁР. БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2.1.Стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, Шивээговь суманд шинэ цэцэрлэг барих. Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийг бодлогоор дэмжих.

2.2.Кембриджийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцах таатай орчныг бүрдүүлэх, гүнзгийрүүлсэн сургалттай анги байгуулах санал, санаачлагыг бодлогоор дэмжих. Урлаг, спортын секц дугуйлан байгуулах, мэргэжлийн багш нарыг цалинжуулах.

2.3.Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 320 хүүхдийн хичээлийн шинэ байрыг барьж ашиглалтад оруулах, сургуулийн гадна болон спорт талбайг стандартын дагуу тохижуулах.

2.4.Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн багтаамжтай, хөгжмийн танхим, биеийн тамирын танхимтай 6 бүлэгтэй өргөтгөлийн барилга барих ажлыг эхлүүлэх, Бага насны хүүхдийн бие бялдрыг хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг эрүүлжүүлэхэд зориулагдах сургуулийн өмнөх боловсролын орчны стандартын шаардлага хангахуйц зориулалтын спортын гадна талбайг бий болгох цогцоор нь шийдвэрлэх

2.5.50 хүүхдийн ор бүхий цэцэрлэгийн хуучин барилгын иж бүрэн засвар хийж тохижуулах.

2.6.Сургуулийн номын сангийн фондыг баяжуулах, сургуулийн лаборатори, тоног төхөөрөмж, багшийн болон сурагч ширээ, сандал, ухаалаг самбар, техник хэрэгслийн хангалтыг орчин үед нийцүүлэн хэрэгжүүлэх.

0000000001

2.7.Багшлах боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, гадаад дотоодын давтан сургалтад хамруулах, Аймгийн “Боловсролыг дэмжих” хөтөлбөр, “Авьяас”, “Ном”, “Багш” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

### **ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНД, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

3.1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй чанартай хүргэх

3.2.Сумын эрүүл мэндийн төвийн шинэ хуучин барилгын байруудыг холбож өргөтгөл хийх, тасаг нэгжүүдийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эмчилгээний, тасаг нээх , орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, гадна талбайг тохижуулах, тусгай зориулалтын автомашинаар парк шинэчлэлт хийх.

3.3.Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн нэгжийн тоног төхөөрөмж болон хэрэгслийг сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах

3.4.Сумын хөдөөгийн багийн эмчтэй болгох, цалинжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нарийн мэргэжлийн үзлэг, оношлогооны чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлэх, эх нярайн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр тусгайлан хөтөлбөр боловсруулан ажиллах.

3.5.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, гадаад, дотоодын давтан сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах.

3.6.Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр, Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн халдварт болон халдварт бус өвчний хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж ард иргэдийг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

3.7.Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэхэд нийтийн биеийн тамирыг чиглүүлэх, чийрэгжүүлэх танхим байгуулах.

3.8.Ахмад настан, зорилтот бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн оношилгоо үзлэгт тогтмол хамруулах

### **ДӨРӨВ. СОЁЛ УРЛАГИЙН БОДЛОГО**

4.1.Сумын 250 хүний суудалтай соёлын төвийг шинээр барих ажлыг шийдвэрлүүлэх.

4.2.Соёлын төвийн хөгжим аппаратур бусад хэрэгсэл, техник тоног төхөрөөмжүүдийг шинэчлэх.

4.3.Шивээговь сумын “Алдрын танхим” –ыг шинээр үүсгэн байгуулах.

4.4.Сумын номын сангийн үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, фондыг нэмэгдүүлэх, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээний мэдээллийн төв болгон хөгжүүлэх.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЛБАР**

5.1.Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээний бизнесийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах.

0000000002



5.2. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, эхний үе шатны төлөвлөгөө, “Монгол мал”, үндэсний хөтөлбөрийн 2 дах үе шатны төлөвлөгөөг аймгийн түвшинд боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

5.3. Малын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлогын хэрэгжилтийг орон нутагтаа оновчтой зохион байгуулах, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.

5.4. Мал амьтны өвчингүй, статустай нутаг болох, махны үйлдвэрүүдийн жишигт хүргэх, мал нядалгааг орчин үеийн шаардлагад нийцсэн Олон улсын стандартад хүргэж мах бэлтгэлийн ложистик сүлжээнд холбох.

5.5. Хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдэд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлж, хүн амаа аюулгүй эрүүл хүнсээр хангах.

5.6. Бэлчээр хамгаалах малчдын бүлэг байгуулан бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг дэмжих, оторын бүс нутагт, аймаг дундын бэлчээр ашиглалтын захиргаатай хамтран ажиллах.

5.7. Хөдөөгийн усан хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх малчдын санаачлагыг дэмжин төсөл хөтөлбөр, орон нутгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй болон гар худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

5.8. Эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан хэрэгжүүлэн тэргүүлэх чиглэлээ болгох.

5.9. Орон нутагт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малчдыг “ Сум хөгжүүлэх сан”, “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-уудын үйл ажиллагааг сайжруулах..

5.10. Хөдөө аж ахуйн зориулалттай техник олгох чиглэлээр “тариалан эрхлэлтийг дэмжих сан”-тай хамтран ажиллах, хадлан бэлтгэх, хүлэмжийн аж ахуй, усалгаатай газар тариалан эрхлэлтийг дэмжих.

5.11. Өрх, иргэдийг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж өөрсдийн хэрэгцээг хангах санаачлагыг дэмжих, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, дэд бүтцийг нь шийдвэрлэх талаар дэмжлэг үзүүлэх.

5.12. Хүнс, хөнгөн үйлдвэр, тээвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг “Сум хөгжүүлэх сан”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн бодлогоор дэмжих. Аутсорсинг үйлдвэрлэлийг жижиг дунд үйлдэр үйлчилгээ эрхлэгчдэд нэвтрүүлэх.

5.13. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засагт оруулах хувь нэмрийг дээшлүүлэхийн тулд хоршооллын бүтцээр дамжуулан бүтээгдэхүүнээ худалдан борлуулах, худалдааны сүлжээ байгуулах, нэгдэн ажиллах үйл ажиллагааг дэмжих.

0000000003



5.14. Улсын болон орон нутгийн чанартай хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

5.15. "Шивээ Овоо" уурхайг түшиглэн "Дулааны цахилгаан станц байгуулах" төслийг бодлогоор дэмжих.

### **ЗУРГАА. ДЭД БҮТЦИЙН САЛБАР**

6.1. Зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн эрүүл, аюулгүй, тохилог орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

6.2. Шивээговь сумыг олон улсын А1А2 автозамтай хатуу хучилттай замаар холбох.

6.3. Шивээговь сумын төвийг олон улсын донор байгууллагуудын тусламжтайгаар "Жишиг сум" болгох ажлыг зохион байгуулна. Энэ ажлын хүрээнд:

6.3.1. Шивээговь сумын төвд хатуу хучилттай авто зам тавих, нийтийн эзэмшлийн талбайд авто зам, явган зам барих, зогсоол, гэрэлтүүлэг, тохижуултын ажлыг цогцоор шийдвэрлэх.

6.3.2. Иргэдийн өмчлөлд олгосон газруудын дэд бүтцийг /инженерийн шугам сүлжээ/ барьж байгуулах, "Хаус хороолол" барих санаачлагыг дэмжих ажлыг бодлогоор дэмжих.

6.3.3. Сумын төвд аж ахуйн нэгжүүдийн санаачлагыг дэмжиж 60 айлын орон сууц барих ажлыг шийдвэрлүүлэх.

6.3.4. Дулааны алдагдал бүхий хуучин орон сууцнуудын фасад дулаалж шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх.

6.3.5. Нэн шаардлагатай байгаа эрүүл ахуйн шаардлагад нийцсэн цэвэр усны эх үүсвэрийг бий болгох, бохир ус зайлуулах шугамыг шинэчлэх, бохир усны цэвэрлэх байгууламжийн асуудлыг шийдвэрлэх.

6.4. Шивээговь сумын уурын зуухыг шинэчлэх, орон сууцнуудын дулааны шугам сүлжээг шинэчлэх ажлыг шийдвэрлэх.

6.5. Хатуу хог хаягдлыг зайлуулж, байгаль орчинд ээлтэйгээр төсөл хөтөлбөрт хамруулах:

### **ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР**

7.1. Ашигт малтмалын нөөцийн талаар судлах, мэдээллийн санг бүрдүүлэх, хамгаалах, ашиглах, олборлолт явуулж буй газарт нөхөн сэргээлт хийхэд хяналт тавьж ажиллах.

7.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулж, бүсийн орчны бүлэг байгуулан ажиллуулах.

7.3. Хог хаягдлыг багасгах, орчны бохирдол доройтлыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх.

7.4. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах, мод үржүүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх.

7.5. Сумын төвд байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшилд байгаа газруудыг ногоон байгууламжтай болгох.

0000000000

7.6.Доройтож талхлагдсан бэлчээрийг хашиж хамгаалах, таримал бэлчээр бий болгох, бороо цасны ус хуримтлуулж цөөрөм, хөв байгуулах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санаачлагыг дэмжих.

7.7.Устаж үгүй болох аюул нүүрлээд байгаа амьтныг /тарвага/ тоо толгойг нэмэгдүүлэх, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

7.8.Бүх нийтийн байгаль орчны боловсролыг дээшлүүлэх, байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх.

7.9.Орон нутгийн аялал зуулчлалын маршрут гаргах, аялалын хөтөлбөртэй болох, амралт зугаалгын зөвшөөрөгдөх бүс, отоглох, хоноглох бүс хил хязгаарыг тогтоож тэмдэгжүүлэх.

7.10.Аялал жуулчлалын цогцолбор, жуулчны бааз байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих.

7.11.Байгаль орчны талаар баримтлах бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх, шинэ мэдээ, мэдээллээр хангахад бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл ашиглан хүргэх.

### **НАЙМ. ТӨРИЙН БОДЛОГО**

8.1.Төрийн албыг мэргэшсэн, чадварлаг, шударга, хариуцлагатай, улс төр, авлигаас ангид албан хаагчдаар бүрдүүлэх, тэднийг ажлын байранд нь давтан сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах.

8.2.Төрийн албаны гажуудал, алдаа дутагдлыг бүрэн арилгах, ил тод нээлттэй байдлыг бүрэн хангах, төр иргэний итгэлцлийг бэхжүүлж, шударга төрийн зарчмыг баримтлан ажиллах.

8.3.Иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг чанаржуулж, сум, багийн засаг дарга нарын ажлын мэдээллийг жилд 2 удаа, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд 1-с доошгүй удаа иргэдэд мэдээлж, үнэлэлт дүгнэлт авч, санал бодлыг нь сонсон үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллах.

8.4.Иргэдэд төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, цаг алдалгүй хүргэх арга хэмжээ авна.

8.5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг чанаржуулан, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх.

8.6.Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг бататгахад чиглэсэн дадлага сургалтыг тасралтгүй явуулах, гамшгийн хор уршгийг арилгах, аврах зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, болзошгүй гамшиг эрсдлийн үед хэрэглэх хүнсний гол нэрийн барааны орон нутгийн нөөц бүрдүүлэх.

8.7.Иргэний бүртгэл мэдээллийг боловсронгуй болгож, холбогдох байгууллагуудтай хамтран иргэдийн шилжилт хөдөлгөөн, гадаадын харьяат иргэдийн бүртгэлийг цэгцлэн, хяналтыг сайжруулах.

8.8.Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах, "Миний байр – манай гэр" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

0000000005  


8.9. Сумдын гадаад харилцааг өргөтгөх, хөрш зэргэлдээх сум, аймгийн төрийн болон бусад байгууллагатай харилцах, туршлага судлах, эдийн засгийн хамтын ажиллагааг хангаж ажиллах.

8.10. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо, санал санаачлагыг тусган ил тод нээлттэй, тэгш боломжийг бий болгох.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

0000000006

